

ТҮҮХИЙГ МАОГИЙНХНЫ ЗАВХРУУЛАХЫН ЭСРЭГ**(Москвад болсон эрдэм шинжилгээ-практикийн
бага хурлын тухай)**

1979 оны 3-р сарын 27-29-ний өдрүүдэд ЗСБНХУ-ын нийслэл Москва хотноо «Маогийнхны зүгээс түүхийг завхруулж байгаагийн эсрэг тэмцлийн нэн чухал асуудлууд» сэдвээр Зөвлөлтийн төв ба холбооны бүгд найрамдах улсуудын эрдмийн хүрээлэн, байгууллагуудын төлөөлөгчид хуран цугларсан эрдэм шинжилгээ-практикийн бага хурал болж, маогийнхан БНХАУ, ЗХУ, БНМАУ болон нийт дэлхий дахины түүхийг хэрхэн гуйвуулж байгаа байдал, марксист түүхчид түүнтэй ямар тэмцэл хийж, няцаалт өгөх тухай асуудлыг авч хэлэлцсэн юм. Тус бага хуралд Зөвлөлтийн нэрт эрдэмтдээс гадна ах дүү социалист орнуудын эрдмийн байгууллагын төлөөлөгчид, түүний дотор мөн манай монголын эрдэмтэд уригдан оролцсон билээ.

ЗСБНХУ-ын ШУА, ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх нийгмийн ухааны академиас эрхлэн хуралдуулсан эрдэм шинжилгээ-практикийн тэрхүү бага хурлын нээлт дээр ЗХУКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нөхөр К. В. Русаков оршлын үг хэлж, Октябрийн хувьсгал мандаж, олон оронд социализм төлөвшин бэхжиж, дэлхийн хөгжлийн явцыг социализм улам улмаар шийдэн тодорхойлох болж байгаа эрин үед томоохон үйл явдал бүхний талаар үзэл суртлын ширүүн тэмцэл өрнөж, ангийн дайснууд социалист орнуудын хоорондын харилцааг аль болохоор мушгин муучилж байгаа бөгөөд маогийнхан хөрөнгөтний үзэл сурталтнуудын нэгэн адилаар түүхийг завхруулах болсон тухай тодорхой ярилаа.

Түүхийн хуудсуудыг сөхөн үзвэл ямарваа түрэмгий этгээд байлдан дагуулалд гарах, аян дайн хийх бэлтгэлээ ихэвчлэн газрын зургийн довтолгоон үйлдэж, түүх, археологи, газарзүйн ил далд «үндэслэл» зохион, бусдын газар нутгийг марган булаалдах явдлаар эхэлдэг байв. Бээжин аль хэдийнээс мөн тийм маягийн үйл ажиллагаанд шилжээд байна.

Бага хурал дээр ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал, сурвалжлагч гишүүн М. И. Сладковский «Түүхийг маогийнхны завхруулж байгаа үндсэн чиглэлүүд» гэдэг гол илтгэлийг тавьж, академич А. Л. Нарочницкий, А. П. Окладников, сурвалжлагч гишүүн С. Л. Тихвинский, П. А. Жилин, А. И. Крушанов нарын зэрэг эрдэмтэд илтгэл хийж, үг хэлэв.

М. И. Сладковский илтгэлдээ даян дэлхийн энх тайван, улс түмний аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулж байгаа Бээжингийн жанжлах дээрэнгүй бодлого, маогийнхны зүгээс түүхийг завхруулж байгаагийн түрэмгий зорилго, стратеги, тактикийн асуудлыг тодорхой дурдаад сүүлийн мянгаад жилийн дотор 700 гаруй жилийн турш кидан, зүрчид, монгол, манж болон японы зэрэг эзэрхэг түрэмгийн дарлалд нэрвэгдэж байсан хятадын өөрийнх нь түүхэнд бусдыг дээрэнгүйлэн жанжлах, хөрш зэргэлдээх улс гүрний газар нутагт өнгөлзөн булаацалдах түүх-эрхэмжийн өчүүхэн ч үндэсгүй, тийм учир маогийнхан нийтийн түүх болоод Хятадын өнгөрсөн үеийн хэрэг явдлыг хамгийн бүдүүлгээр мушгин гуйвуулж байна гэж тэмдэглэв. Мөн түүнчлэн хүннүгийн аян дайн, монгол

манжийн хаадын байлдан дагууллыг шагшин магтаж, Чингис хааныг хятадын төрийн зүтгэлтэн мэт болгож харуулахыг оролдож байгаа нь жанжлах түрэмгий бодлогоо түүхийн үүднээс үндэслэх эчнээ зорилго агуулж буй тухай илтгэлд дурдав. XIX зууны үед Англи, Францын түрэмгийлэлд автаж байгаад XX зууны үед гагцхүү Октябрийн хувьсгалын дараа зөвлөлтийн тусламж дэмжлэгээр ардын ардчилсан хувьсгалыг ялалтанд хүргэж, тусгаар тогтнолоо олж авсан Хятад орны нам, төрийн эрх баригчид нь одоо болоход харин Орос ба Зөвлөлт Холбоот Улсыг хэзээнээс хятадын газар нутаг, биеэ даасан байдалд аюул учруулж байсан «гол дайсан» мэт дүрслэж, хятадын ард түмнийг их хан үндэстний дээрэнгүй үзлээр мунхаруулж, дэлхийн олон нийтийн санаа сэтгэлийг үймүүлэх оролдлого хийж байгаа нь бүх талаар ёс зүйн гадна хэрэг юм. Түүхийг тэд зөвхөн хятадын хаад, жанжин нарын дурын хэрэг байсан мэт дүрсэлж, материалист диалектик, түүхийн материализмын сургаал заалтыг хөсөрдүүлэхийг юман төдийд бодохгүй байна.

Гэвч марксист-ленинист сургаал, Зөвлөлт Холбоот Улсын социализм, коммунизмын байгуулалтын онол, практик, олон улсын коммунист ажилчны ба үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний туршлагыг судалж суралцах явцын дунд ялангуяа 1949 оноос хойшхи эхний арваад жилийн дотор БНХАУ-д Фань Вэньлань, Цзянь Боцзань, Шан Юэ нарын зэрэг марксист түүхчдийн эгнээ бий болж бэхжин байв. Тэд гоминьданы идеалист харгис сургаалыг даван туулж, хятадын түүхийн марксист баримтлалыг боловсруулан, улмаар Орос, Зөвлөлтийн ба дэлхий нийтийн түүхийг материалист ёсоор үзэх болж багагүй амжилт олж байсан нь талаар өнгөрсөнгүй. М. И. Сладковскийн цохон тэмдэглэсэнчлэн «1950-иад оны үед баталсан, шилжилтийн үеийн (1949—1967 он) жанжин шугамын талыг баримтлагч, хятадын интернационалч коммунистуудын эсрэг Мао Зэдүний ба түүнийг аялдан дагалдагчдын айлган сүрдүүлж, үй олноор хэлмэгдүүлэх үйл ажиллагаа хэдий хүнд бэрх байсан боловч хятадын газар нутаг дээр цацагдан үндэслэсэн үр нь нэгэнт хөврөлөө дэлгэж нахиалаад, маогийнхан түүнийг одоо болтол бүрмөсөн бяцлан гишгэж чадахгүй байна»¹

Академик А. П. Окладников хятадын археологич нар хэрхэн Бээжингийн удирдагчдын захиас даалгавар, албадлага шахалтаар Хятадыг хүн төрөлхтний үүсэл хөгжлийн гол өлгий нутаг байсан мэт дүрслэн харуулахыг махран оролдолхийлж байгааг баримтаар харуулж, ул үндэстэй няцаалт өгөв. Одоогоос 3-4 зуун мянган жилийн өмнө хятадад байсан синантроп хэмээх мичин хүний оршин амьдарч байсан эрин цагийг эрт цагийг эрт цаг тийш зохиомлоор татах, түүний үйлдэн хэрэглэж байсан чулууны соёлыг улам бүрдүүлэг болгон дүрслэх замаар тэр бол дэлхий дээр хамгийн эртний хүн байсан, түүнээс хятадуудын хамт бусад улс түмэн салбарлан гарсан гэдэг ойлголт төрүүлэхээр маогийнхан бүдүүн хадуун мэтгэн зүтгэж байна. Гэтэл Европоос синантропын үеийн мичин ба заримдаг мичин хүний яс, Явын арлаас одоогоос 1 сая жилийн өмнө байсан питекантроп хэмээх мичин хүний яс аль XIX зууны эцэс XX зууны эхээр олдсон билээ. Монгол, Зөвлөлтийн нутгаас синантропын үе, түүнээс өмнөх үеийн ч мичин хүний хэрэглэж байсан хуучин чулуун зэвсгийн доод үеийн олбор олоод байна. Ялангуяа Африкаас олдсон мичин хүний ул мөрийн зүйл 2-4 сая жилийн алс тэртээх балар эртний үед хамаарах учир Хятадыг хүн төрөлхтний өлгий нутаг гэх үндэс огт алга.

Академик А. Л. Нарочницкий «ЗСБНХУ-ын түүхийн үндсэн шатуудыг маогийнхны завхруулж байгаа нь» гэдэг илтгэл тавьж, хятадын түүхчид Оросыг Ази, Европод колоничлолын бодлого явуулагч гол эзэрхэг

¹ «Проблемы дальнего Востока» сэтгүүл, 1979, № 2, 27-р тал.

түрэмгий гүрэн байсан ЗХУ бол түүнийг уламжлан үргэлжлүүлж байгаа мэтээр асуудлыг буруу тавьж, улмаар Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн хүрээнд социалист орнууд Зөвлөлттэй хамтран ажиллах явдлыг ашиггүй, харин ч хохиролтой гэх зэргээр гүтгэж байгаад нь ул үндэстэй няцаалт өгөв. Ялангуяа Кавказ, Дундад Ази, Казахстан, Сибирийн ард түмнүүдийг харийн дарлалаас чөлөөлж, тэдгээр ард түмнүүд сайн дурын үндсэн дээр Оросод анх нийлэн нэгдсэн явдлын дэвшилт шинж чанарыг үгүйсгэж, Зөвлөлтийн холбооны бүгд найрамдах улсуудыг Оросод дарлагдан байгаа мэтээр дүрслэж, зөвлөлтийн ард түмний түүх-нийгэмжийн интернационалч нэгдэл нягтралыг задлах бүтэлгүй хорон санаат оролдлого хийж байгаа нь маогийнхны зүгээс гаргаж буй социализм, коммунизмын эсрэг үйл ажиллагааны нэг хэсэг юм. А. Л. Нарочницкий илтгэлдээ маогийнхан түүхийг завхруулан будлиулж, зөвлөлтийн эрдэмтдээр оросын хаант засаг, манжийн хаадын түрэмгий бодлогыг цагаатгуулах гэж байгаа бол тэр бүтэхгүй хэрэг, зөвлөлтийн түүхийн шинжлэх ухаан нь хэзээ ч тийм үзэл баримталж байгаагүй, хойшид ч баримтлахгүй, «түүхийн үйл үзэгдлүүдийг үнэлэн дүгнэхдээ түүхэн, ангич хандлагаас алхам төдий ч ухралгүй, үндэсний ба орон нутгийн явцуурлын бүх илэрлийг няцаан» «Хаант Орос болон бусад улс орны, түүний дотор мөн хятадын тухайд гагцхүү ангич, намч ленинч задлаг шинжилгээ хийж үнэлэн дүгнэх нь найдвартай»¹ гэж цохон тэмдэглэв.

Зөвлөлт Казахстаны академич Б. А. Тулепбаев «Казахстаны түүхийг маогийнхан гуйвуулж байгааг шүүмжлэх нь», Зөвлөлт Киргизийн ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Т. Табышалиев «Зөвлөлт Киргизстаны түүхийг маогийнхан завхруулж байгаа нь» Зөвлөлт Тажикстаны Академич Б. И. Искандаров «Маогийнхан Дорнод Памирын нэн шинэ үеийн түүхийг завхруулж байгаа нь» гэдэг илтгэл тавьж Казахстан, Киргиз болон нийт Дундад Азид өнгөрсөн үеийн турш ямар ч хятад тосгон суурин, хятадын засаг захиргаа байгаагүй бөгөөд Памир зэрэг Тажикстаны аль ч нутаг хятадын харьяанд орсон түүхгүй юм гэж тэмдэглэв.

ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Л. Тихвинский «Их хан үндэстний жанжлах үзлийг дэвэргэхийн эсрэг тэмцэл бол түүхийн шинжлэх ухааны чухал зорилт мөн» гэдэг илтгэл тавьж, хятадын маоист түүхчид гоминьданы үндсэрхэг дээрэнгүй үзлийн өвийг шууд уламжилж, улмаар хятад хүний хөл гишгэсэн бусад улс орны газар бүхэн хятадын бүрэлдэхүүнд байх ёстой гэсэн жанжлах түрэмгий бодлогыг түүх гуйвуулах замаар үндэслэх гэж байгааг Хятад, Ази ба дэлхийн олон улсын хоорондын харилцааны түүхийн баримтаар илчилж няцаалт өгөв. Хятадын эрт дээр үеэс эхлэн олон ястны салаа мөчир бүхий нэгдмэл нэгэн их хан үндэстнээс бүрэлдсэн олон үндэстний улс байсаар ирсэн, тийм учир манж, монгол, уйгур, төвд зэрэг бусад үндэстэн угсаатан бол цөм үеийн үед хятадын их улс гэрийн салшгүй хэсэг байх ёстой гэж маогийнхан түүхийн үүднээс нотлон үнэмшүүлэхийг хичээж байгаа нь түүхийн үйл явцыг түүхэн зарчмаар авч үзэх марксист аргагүйн асуудалтай харшилж байна.

Доктор В. Н. Виноградов маогийнхны зүгээс Төв ба Зүүн Өмнөд Европын улс түмний түүхийг гуйвуулж, тэднийг Орос түрэмгийлж байсан мэтээр дүрслэн харуулахыг оролдож байгаа тухай дурдаад үнэн хэрэг дээрээ өмнөд ба өрнөд славян нар болон Грекийг Османы туркийн хэдэн зуун жилийн талхигдлаас чөлөөлөгдөж үндэсний төр улс, тусгаар тогтнолоо сэргээхэд Орос улс дэвшилт үүрэг гүйцэтгэсэн тухай бодит баримт гаргаж, тодорхой ярилаа. Хаант Оросын хувьд маогийнхан шиг зөв-

¹ А. Л. Нарочницкий, Маоистские фальсификации основных этапов истории СССР, гар бичмэл-ДДСХ-гийн бичмэлийн санд.

хөн хаант засгийн харгис түрэмгий бодлогыг харж, гол болгоод Оросын ард түмний дэвшилт, ардчилсан хувьсгалт үйл ажиллагаа болон нааштай нөлөөг олж харахыг үл хүсэх нь ихээхэн харалган бөгөөд даанч явцуурсан хэрэг юм.

Түүхийн ухааны доктор А. М. Григорьев «Маоист түүх судлалд ХКН, хятадын хувьсгалын түүхийг гуйвуулж байгаагийн өнөөгийн шат («зарим үндсэн хандлагууд») гэдэг илтгэл тавьж. Мао Зэдүн, түүний хань хамсаатан нар 1930-аад оны үеэс эхлэн ХКН, хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн түүхийг хэрхэн субъектив идеалист аргаар мушгин гуйвуулсаар ирсэн тухай тодорхой яриу.

Түүхийн ухааны дэд эрдэмтэн, нангиадач Р. Вяткин «Орчин үеийн хятадын түүх судлалд дэлхийн нийтийн ба Азийн улс түмний түүхийн тухай дурдаж байгаа зүйлс» гэдэг илтгэл тавьж, Хятад, Монгол, Ази, Европын түүхийг маогийнхан хэрхэн завхруулж байгаа тухай яриу. Маогийнхан европ бол ертөнцийн түүх, соёлын төв мөн гэдэг хөрөнгөтний онолыг шүүмжлэх нэрийдлээр Ази, тухайлбал хятад улс дэлхийн хөгжлийн төв байв. Хятад тэргүүтэй шар арьстан XV зууны үе хүртэл хүн нийгмийн хөгжлийг манлайлан чиглүүлж байсан гэсэн арьсны үзлийн үнэр ханхалсан хятад төвийн үзэл дэлгэж байна.

Хятадын ард түмний түүх, соёлын уламжлал, нөлөө хэдийгээр багагүй боловч асуудлыг ингэж тавих нь түүхэн үнэнд өчүүхэн төдий ч нийлэхгүй байна.

БНМАУ-аас ШУА-ийн дэд ерөнхийлөгч академич Ш. Бира, доктор Н. Ишжамц нар «БНМАУ-ын түүхийг маогийнхны завхруулж байгаа байдал ба түүхэн үнэн» гэдэг илтгэлтэйгээр тус хуралд оролцов. Академич Ш. Бира илтгэлдээ маогийнхны зүгээс Хятадыг ертөнцийн төв гэж үзэж, Монгол зэрэг Төв Азийн нүүдэлчдийн төв улс түүх, соёлын биеэ даасан байдлыг үгүйсгэх, хүннү, Чингис болон манжийн хаадын аян дайныг шагшин магтаж, тэднийг бүгдийг хятадын харьяаны хүмүүс мэт болгон, хятад их гүрний жанжлах дээрэнгүйллийг үндэслэхийг оролдох, Монголын ард түмний тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний тэмцлийг үгүйсгэн муучилж, Монголыг угаасаа хятадын бүрэлдэхүүний хэсэг байсан мэтээр дүрслэн харуулах, 1921 оны Монгол ардын хувьсгалыг Хятадын цэргийн эрхтний ноёрхлын эсрэг хандсан биш, зөвхөн Оросын түрэмгийллийг эсэргүүцсэн тэмцэл байсан учир цаашдаа Монгол орон хятадын харьяанд ороход саад болох ёсгүй гэсэн сэтгэгдэл төрүүлэх, Монгол-Зөвлөлтийн ард түмний мөнхийн ган бат найрамдлын мөн чанар, ач холбогдлыг мушгин гуйвуулах зэрэг маоизмын үзэл онолын хор уршгийг шүүмжилж, түүхэн үнэнийг материалист диалектикийн ёсоор үнэн бодит байдалд яв цав тохируулан судлахын чухлыг зааж яриу. Мөн маоизмын харгис үйл ажиллагааг уудлан илэрүүлэхэд Төв Азийн нүүдэл иргэншил, Монгол, түрэг, манж, төвд угсаатны нийгэм эдийн засаг төр, соёл, шашин, зан заншлын биеэ даасан өвөрмөц шинж төрх, Төв Ази, Иран, Энэтхэг зэрэг бусад зарим улс түмэнтэй нягт харилцаатай байсан баримтыг тодруулж, марксист дүн шинжилгээ хийх нь чухал гэж цөхөн тэмдэглэв. Түүнчлэн маогийнхан БНХАУ-ын хятад биш үндэстэн ястны асуудлыг шийдвэрлэхэд үндэстний өөртөө засан тохинох эрх, капиталист биш хөгжлийн тухай В. И. Лениний мэргэн сургаалыг огт үл хэрэгсэн огоорч, үндэстний дээрэнгүй үзлийн бодлого явуулсаар байгаа нь марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын ариун зарчим, БНХАУ-ын бүх үндэстэн ястны ашиг сонирхолд эрс тэс харшилж байгаа тухай илтгэлийн дотор тодорхой дурдав.

Бага хурлыг даргалж хуралдуулсан зөвлөлтийн академич Е. М. Жуков хурлыг хааж хэлсэн төгсгөлийн үгэндээ: маоизмын жанжлах дээрэн-

гүй үзэл, түүх завхруулгын эсрэг марксист түүхийн шинжлэх ухаан, дэвшилт түүхчдээс баттай баримт, найдвартай арга-зүйн үндэс бүхий нарийн судалгаа хийж, өргөн далайцтай тэмцэл хийхийн чухлыг заасан нь марксист түүхийн шинжлэх ухааны хөгжлийн ээлжит чухал зорилтуудыг яруу тодорхойлсон хэрэг гэж бид үзнэ. Монгол ба Төв Азийн нүүдэл иргэншлийн түүх, Монгол-Хятадын харилцаа, социалист системийн орнууд болон дэлхийн бусад улс түмний түүхийн талаар маогийнхны завхруулгын алив хэлбэрийг илрүүлэн няцааж, марксист-ленинист үзэл онолын үндсэн дээр түүхэн үнэнийг сэргээх үйлсэд манай эрдэмтэд ЗХУ зэрэг ах дүү социалист орны эрдэмтдийн хамт нилээд зүйлийг сэдэн хийсээр ирсэн бөгөөд цаашид нэн ихийг бүтээх болно.

Д-р. Н. Ишжамц.